



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 1/29

Улаанбаатар хот

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/45 дугаар тушаалаар баталсан “Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрэм”-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

- 1.1. 4.1.6, 5.1, 5.4.5, 5.4.8, 5.4.9, 5.4.11 дэх заалтуудыг тус тус хүчингүй болгох;
- 1.2. 4.2.6-д “давтан сургах, дадлагажуулах” гэсний дараа “ажлыг зохион байгуулах” гэж нэмэх;
- 1.3. 5.4.6-д “ИНҮТ-ийн дотоод зохион байгуулалтын бүтцийн нэгж (газар, хэлтэс, тасаг, алба)-ийн дарга, ажилтнууд болон харьяа салбар, нэгжийн удирдах ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажилд томилох, чөлөөлөх, шилжүүлэн ажиллуулах, дотоодод томилолтоор ажиллуулах, чөлөө олгох, сахилгын шийтгэл ногдуулах, шагналд тодорхойлох, ажлын үр дүнг тооцох, цалин хөлс, тэтгэмж, тусламж олгох болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх;” гэснийг “ИНҮТ-ийн зохион байгуулалтын бүтцийн нэгж (дарга; дэд дарга; захирал; дэд захирал; газрын дарга; менежер; ерөнхий нягтлан бодогч; ерөнхий инженер; алба, хэлтэс, тасгийн дарга; эрхлэгч нарыг ИНЕГ-ын дарга)-ийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажилд томилох, чөлөөлөх, шилжүүлэн ажиллуулах, дотоодод томилолтоор ажиллуулах, чөлөө олгох, сахилгын шийтгэл ногдуулах, шагналд тодорхойлох, ажлын үр дүнг тооцох, цалин хөлс, тэтгэмж, тусламж олгох болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх” гэж өөрчлөн найруулах.

2. Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан холбогдох дүрэм, журам, баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газар (П.Ариунболд)-т, дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (П.Мөнхжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

17120 0263

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ч.Нямсүрэн), Дотоод аудитын алба (Н.Мөнхсүрэн) -нд тус тус даалгасугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН